



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/09

Сээхүүл

Мал үржлийн ажил зохион байгуулах  
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, 29.2 дахь заалт, "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1, 4.5.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.4.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1.6, 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.3, 14.2.10, 14.2.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал үржлийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

Ш.БУЯННЭМЭХ – Мал эмнэлэг  
үржлийн тасгийн дарга

ГИШҮҮД:

С.ОТГОНБААТАР – 2 дугаар багийн  
Засаг дарга

Л.ХУЛАН – Мал эмнэлэг үржлийн  
тасгийн мэргэжилтэн

2. Мал үржлийн ажлыг 2017 оны 02 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд чанарын өндөр түвшинд, технологийн дагуу гүйцэтгэж, ажлын тайланг сумын Засаг даргад танилцуулахыг Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга /Ш.Буяннэмэх/-д үүрэг болгосугай.

3. Ажлын удирдамжийг 1 дүгээр, ажлыг гүйцэтгэхэд зарцуулагдах шатахууны зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Ажлыг гүйцэтгэхэд зарцуулагдах шатахууны зардал 211000 /хоёр зуун арван нэгэн мянга/ төгрөгийг Мал хамгаалах сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Болормаа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



В. БАТ-ЭРДЭНЭ

D:\My Documents\zaxiramj.doc

Сумын Засаг даргын 2017 оны ... -р сарын ... -ны өдрийн ... дугаар захирамжийн ... -р хавсралт



### Мал үржлийн ажил явуулах удирдамж

Зорилго: Сумын нутаг дэвсгэрт байгаа малчин өрхийн хээлтүүлэгчийг эх сүргээс нь ялган, ангилалт, хянан баталгаажуулалт хийх

#### Сумын түвшинд хийгдэх ажил:

- Ангилалт, баталгаажуулалт хийх
- Малчин өрхүүдээр орж хуц, ухныг хариулагчийн хөлсний хамт авч, хуц ухна маллагчид хүргэж өгөх
- МЭҮТ-ийн дарга, багийн Засаг дарга нар ажлын мэдээллийг малчин, мал бүхий иргэдэд мэдээлж бэлтгэл ажлыг хангуулах

#### Мал эмнэлгийн байгууллага, аж ахуйн нэгжийн хийх ажил:

- Хуц, ухна маллагчид хүлээлгэн өгч байгаа хуц, ухны эрүүл мэндэд үзлэг хийх

#### Мал зүйчийн хийх ажил:

- Бог малын хээлтүүлэгчийг ангилалт баталгаажуулалтанд бүрэн хамруулна.

#### Малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийн түвшинд:

- Хуц, ухнаа бэлэн байлгах, маллагчийн хөлсийг бэлэн өгөх

Удирдамж боловсруулсан:

МЭҮТ-ийн дарга *Ш. Буянч* /Ш.Буяаннэмэх/

Сумын Засаг даргын 2017 оны...-р  
сарын...-ны өдрийн... дугаар  
захирэмжийн...-р Хэвсрэлт



Ажлыг гүйцэтгэхэд зориулах шатахууны зардал

2017.02.14.

| № | Нийт явах зай/км/ | Зарцуулах шатахуун | Шатахууны үнэ/төг/ | Нийт үнэ |
|---|-------------------|--------------------|--------------------|----------|
| 1 | 683               | 100/18 123л        | 1720               | 211,000  |

Төсөв хийсэн

МЭҮТ-ийн дарга *Ш. Буяннэмэх* Ш.Буяннэмэх